

СЭТГҮҮЛИЙН БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН АНГИЛЛЫН АСУУДАЛД

М.Наранмандах*

* "Соёл-Эрдэм" дээд сургуулийн сургалтын албаны дарга, магистр, докторант

Түлхүүр үг: сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйл, сонин, сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлийн ялгаа, сэтгүүлийн голлох бичлэгийн төрөл зүйл, шинэ бичлэгийн төрөл зүйл.

Сэтгүүл зүйн бичлэгийг мэдээллийн төрөл (мэдээ, тайлан, ярилцлага, сурвалжлага, тойм, номзүй, сурвалжилсан тэмдэглэл, захидал), шинжлэлт төрөл (өгүүлэл, хэвлэлийн тойм, шүүмж, төрөгдөл), нийтлэл уран сайхны төрөл (найруулал, шог найруулал, улс төрийн шог, тэмдэглэл, уран нийтлэл) гэсэн үндсэн гурван төрөл, мөн бичлэгийн жижиг зүйлүүд (мэдээллийн шинжтэй асуулт-хариулт, товч намтар, эмгэнэл, зарлал, блиц асуулт, шинжлэн дүгнэсэн шинжтэй яриа, тайлбар, анкет, хэвлэлд зориулсан албан мэдээлэл, мониторинг, прогноз, рейтинг, туршилт, хүлцэл, зөвлөмж, нийгмийн судалгааны дүн, уран сайхны шинжтэй домог, шог яриа, элэглэл, хоч шүлэг, сэдэл шүлэг, наргиа, тоглоом, сонжоо, үгийн сүлжээ, оршлын бичиг, ертөнцийн сонин хачин)¹ гэж нийт дөрвөн төрөлд хувааж үздэг.

Миний бие сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлийг тодорхойлохын тулд 2009

оны "Компьютер таймс" (10 дугаар), "Гялбаа" (12 дугаар), "Алтан гадас" (10 дугаар), "UPTOWN" (11 дугаар) сэтгүүлийн бүтэн жилийн, "TV ZONE" (25 дугаар) сэтгүүлийн хагас жилийн дугаарт судалгаа хийлээ. Нийт сэтгүүлийн 68 дугаарын бичлэгийн төрөл зүйлд ажиглалт хийв. Ингэхдээ сүүлийн жилүүдэд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байгаа олон уншигчтай, чансаатай сэтгүүлүүдийг сонгож авсан болно.

"Компьютер таймс" сэтгүүл нь 2003 оноос хойш техник, технологи, тэр дундаа мэдээллийн технологийн талаарх мэдээ, мэдээллийг цаг тухайд нь хүргэдэг, өөрийн уншигч, захиалагчдын хүрээ, орон зайг хэдийнэ бий болгож чадсан нь багагүй хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаагаас нь харагдаж байна. Мөн "Гялбаа" сэтгүүл нь зах зээл дээр хамгийн удаан, тогтвортой оршин тогтнож байгаа сэтгүүлийн нэг бол "UPTOWN" сэтгүүлийн хувьд хамгийн олон уншигчтай сэтгүүлээр шалгарсан нь түүний зах зээл дэх байр суурийг илэрхийлж байна. Харин "TV ZONE" нь Монголын сэтгүүлийн зах зээл дээр хугацаа болоод маркетингийн хувьд шинэлэг төдийгүй, бусад төрлийн сэтгүүлтэй өрсөлдөх чадвар бүхий олон

нийтэд зориулагдсан шинэ сэтгүүл юм. Тус сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь гэр бүлийн гишүүн бүрт зориулсан мэдээ, мэдээлэл өгөх зорилготой. "TV ZONE" сэтгүүлийн араас түүн шиг долоо хоногийн телевизийн хөтөлбөр хэвлэдэг "INFO", "ТВ 7 хоног" зэрэг сэтгүүл гарч ирсэн бөгөөд бүгд л нэгэн ижил агуулга, өнгө төрхтэй болж байна. Хамгийн сүүлд ийм хэвлэлийн тоог нэмж "ТОЙМ" сэтгүүл зах зээл дээр гарч ирсэн. "Алтангадас" сэтгүүл нь "Хөгжлийн төлөө хамтдаа" уриан дор нийгэм, улс төр, эдийн засгийн сэдвээр мэдээ мэдээлэл нийтэлдэг. Олон нийтэд зориулсан, улс төр-нийгэм, эдийн засаг, мэргэжлийн чиглэлийн эдгээр сэтгүүл нь өнөөгийн сэтгүүлийн өнгө төрх, байр суурийг илэрхийлж чадна гэж үзэж байна.

Сэтгүүл нь Монголын тогтмол хэвлэлийн зах зээл дээр хугацааны хувьд 80 гаруй жил оршин тогтнож, өөрийн өнгө төрх, нийтлэлийн бодлого, бичлэгийн төрөл зүйл, хийц дизайн, хэлбэрийн хувьд үргэлж хувьсан өөрчлөгдөж ирсэн уламжлалт мэдээллийн хэрэгсэл билээ. Тийм ч учраас сэтгүүлийн онцлог, ялангуяа бичлэгийн төрөл зүйл нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа

сонины бичлэгийн төрөл зүйлээс ялгарах онцлогийг нь судлахыг зорьсон билээ. Хэлбэр, агуулга, зориулалтын хувьд сонины бичлэгийн төрөл зүйлээс ихээхэн ялгаатай, өөрийн онцлог бүхий сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйл бүрэлдэн тогтсон болох нь бидний судалгаанаас тодорхой харагдаж байна. Сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйл нь:

1. Мэдээллийн,
2. Уран сайхны,
3. Бичлэгийн жижиг буюу туслах

зүйлүүд гэсэн төрөлд ангилагдаж байна. Ингээд бичлэгийн төрөл зүйл тус бүрээр нь нарийвчлан авч үзье. Сэтгүүлийн хувьд дугаар бүрт алгасалгүй, тогтмол олон тоогоор гардаг бичлэгийн төрөл зүйл нь мэдээ юм. Сэтгүүлд өдөр тутмын шуурхай мэдээ гардаггүй. Өдөрт болсон мэдээллийг өдрийн тутмын сонин маргааш нь нийтэлдэг бол сэтгүүлд тэгэх боломжгүй. Учир нь цаг хугацаа, гарах давтамжийн хувьд долоо хоногоос дээш байдаг тул шуурхай мэдээ гаргах боломжгүй юм. Судалгаанаас харахад сэтгүүлийн мэдээний ихэнх нь орчуулгын байна. Мөн дэлгэрэнгүй мэдээ ч гарч байна.

Хүснэгт №1

Сэтгүүлийн мэдээний бүтэц (2009 оны бүх дугаарт)

Д/д	Сэтгүүлийн нэр	Нийт мэдээ	Дотоод мэдээ	Гадаад мэдээ	Дэлгэрэнгүй мэдээ	Нийт материалд эзлэх хувь
1.	Алтангадас	53	19	25	9	424/12.5%
2.	Гялбаа	33	3	30	-	353/9.3%
3.	Компьютер таймс	56	6	43	7	805/6.9%
4.	TV ZONE	282	170	88	24	1254/22.4%
5.	UPTOWN	278	114	159	5	839/33.1%

"Компьютер таймс" сэтгүүлийн "Дотоод мэдээ", "Гадаад мэдээ", "КТ-ын тоймч"; "UPTOWN" сэтгүүлийн "Хотын соёл", "Шинэ технологи", "Оддын мэдээ"; "Гялбаа" сэтгүүлийн "World news"; "TV ZONE" сэтгүүлийн "Сонин хачин", "Z-news", "Mini news" булан зэрэг нь мэдээллийн булан юм. Харин "Алтангадас" сэтгүүлийн хувьд тогтсон мэдээллийн булангүй бөгөөд дунджаар нэг дугаарт хоёр мэдээ хэвлэгдсэн байна. № 67, 68 дугаарт нэг ч мэдээ нийтлэгдээгүй байна. Жилийн турш энэ сэтгүүлд нийт 53 мэдээ хэвлэгдсэн нь нийт материалын 12.5%-ийг эзэлж байна. Сонины хувьд ч сэтгүүлийн нэгэн адилаар мэдээллийн бичлэгийн төрөл, тэр дундаа мэдээ зонхилох хувийг эзэлж байна. Тухайлбал, "Улаанбаатар таймс" сонины 2005 оны 3-р сарын 20 дугаарт нийт 676 мэдээ гарсан бөгөөд 9 орчим хувь буюу 63 нь гадаад мэдээ байсан бөгөөд өдөрт дунджаар 35 дотоод мэдээ, 3 гадаад мэдээ гардаг, "Зууны мэдээ" сонины 2000-2005 оны 144 дугаарын бичлэгийн төрөл зүйлийг ангилахад мэдээ 62,4%, "Өнөөдөр"

сонины 2004 оны 3-р сарын нийт дугаарт 898 материал орсноос 688 нь мэдээ байна. Үүнээс харахад сэтгүүл, сонины бичлэгийн төрөл зүйлд мэдээ зонхилох хувийг эзэлж байгаа тодорхой байна. "...90-ээд оны эхэн үеэс мэдээллийн бичлэг сэтгүүл зүйн хамгийн эрэлт хэрэгцээтэй болж хувирсан юм. Үүнтэй уялдан сонин, радио, телевизийн нийтлэл, нэвтрүүлэгт мэдээний эзлэх хувь эрс нэмэгдэж, сэдвийн хүрээ нь огцом тэлж байна"² гэсэн судлаачийн дүгнэлтийг энэ нь баталж байна.

Мэдээний дараа тогтмолжиж байгаа бичлэгийн төрөл зүйл нь ярилцлага юм. "Ярилцлага гэдэг бол сэтгүүлч, ярилцагч хоёр ямар нэг асуудлын талаар ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлэг бүтээхэд зориулан хийсэн тодорхой зорилго бүхий харилцан ярианаас бүтсэн мэдээллийн бичлэгийн зүйл мөн"³. Ярилцлага нь давтамжаараа сонин, сэтгүүлийн аль алиных нь хувьд мэдээний дараа орох бичлэгийн төрөл зүйл болсон байна. Ярилцлага нь хуудас дамнасан том хэмжээтэй байх агаад нэг дугаарт хэд хэдээрээ ордог.

Хүснэгт №2

Ярилцлага

д/д	Сэтгүүлийн нэр	Ярилцлагын тоо	Нийт материалд эзлэх хувь
1.	Алтангадас	22	424/5.1%
2.	Гялбаа	46	353/13%
3.	Компьютер таймс	16	805/2%
4.	TV ZONE	68	1254/5.4%
5.	UPTOWN	59	839/7%

"Гялбаа", "Компьютер таймс", "TV ZONE", "UPTOWN" сэтгүүл дугаар бүртээ

ярилцлага нийтэлдгээс гадна нэг дугаарт хамгийн бага нь нэг, хамгийн их

нь 10 ("UPTOWN", №26, 2009 оны 12-р сар) ярилцлага орсон байна. Дунджаар нэг дугаарт 3-5 ярилцлага оржээ. Харин "Алтангадас" сэтгүүлийн 2009 оны 10-р сарын №70 дугаарт нэг ч ярилцлага ороогүй бөгөөд бусад дугаарт 1-4 ярилцлага нийтлэгджээ. Үүнээс харахад ярилцлага нь сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлд томоохон байр эзэлж, үндсэн бичлэг болсон нь илэрхий байна. "Ярилцлага нь мэдээлэх, танин мэдүүлэх, зохион байгуулах, гэгээрүүлэх шинжийг агуулж байдаг олон талын ач холбогдолтой зүйл юм"⁴.

Сэтгүүлийн ярилцлагад ажиглагдсан өөр онцлог бол рекламн шинжтэй ярилцлага цөөнгүй хэвлэгдэж байгаа явдал юм. Тухайлбал, "UPTOWN"-ы №17-д хэвлэгдсэн "Инлин-гуа" олон улсын хэлний төвийн менежертэй хийсэн "Дэлхийн чанар Монголд" ярилцлага нь рекламн шинжтэй байсан бол "Чулуу амилуулдаг өвөө" ярилцлага нь нийтлэлийн маягтайгаар бичигджээ. Мөн "Гялбаа" сэтгүүлийн №54 дугаарт гарсан "JP CENTURY GLOBAL" компанийн захирал Д.Мөнхсаруултай хийсэн "Дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх дээд боловсролыг эзэмшицгээе" ярилцлага, №65 дугаарт гарсан "Sky resort" цанын баазын тухай ярилцлага нь рекламн шинжтэй байлаа. Тэр ч байтугай зарим нэг сэтгүүл рекламаа ярилцлагын хэлбэрээр хийсэн нь ажиглагдлаа. Тухайлбал, "TV ZONE" сэтгүүлийн №82 дугаарт "Хайрын record" киноны танилцуулга, рекламн гол дүрд нь тоглосон жүжигчидтэй ярилцлага хэлбэрээр хийж нийтэлсэн бол "Алтангадас" сэтгүүлийн №65, 66 дугаарт "Гүүний хуурай саам гайхамшигтай эрүүл хүнс",

№69 дугаарын "Хүүхдийн хүмүүжил" буланд "Онсьхон" цэцэрлэг, "Маамуу нааш ир" төвийн захиралтай хийсэн ярилцлага нь цэвэр реклам байсан учраас эдгээрийг реклам гэж үзлээ.

Сэтгүүлийн хувьд сониноос ялгарах бичлэгийн төрөл зүйл нь фото мэдээ, фото сурвалжлага юм. Сонины хувьд мэдээ, мэдээллээ баримтжуулах, уншигчдын анхаарлыг татах, чимэглэх зорилгоор фото зургийг тавьдаг бол сэтгүүлийн хувьд фото зургийг мэдээлэх зорилгоор түлхүү ашигладаг. Энэ нь дан фото мэдээ, сурвалжлагууд тогтмолжих болсноос харагдаж байна. Фото мэдээ гэдэг нь үйл явдлыг ганц буюу хоёр кадр зургаар уншигчдад шуурхай гарган үзүүлсэн жанр юм. Фото мэдээ бол болсон үйл явдлын талаар уншигчдад илүү итгэл үнэмшил төрүүлдэг чухал зүйл мөн. Фото нь үйл явдлын сонирхолтой агшин, хормыг буулгаж чадсан бол үр нөлөөтэй бөгөөд тод сайн байх нь сэтгүүлийн өнгө үзэмж, дизайнд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Судалгаанд хамрагдсан сэтгүүлээс эмэгтэйчүүд, залуучуудад зориулагдсан "Гялбаа", "UPTOWN" сэтгүүлийн бүтэн жилийн дугаарт 16-22 фото мэдээ нийтлэгдсэн нь хамгийн олон нь юм. Харин "Алтангадас" сэтгүүлд жилийн турш нэг ч фото мэдээ хэвлэгдээгүй байна. Энэ нь тухайн сэтгүүл хэнд чиглэж, ямар нийтлэлийн бодлого барьж байгаагаас шалтгаалж буй юм. Өөрөөр хэлбэл, олон нийтэд зориулсан сэтгүүл нь фото мэдээ, фото сурвалжлагыг түлхүү хэвлэж байгаа бол мэргэжлийн болон нийгэм, улс төрийн чиглэлийн сэтгүүлүүд фото мэдээ, фото сурвалжлагыг бараг нийтлэхгүй байна.

Тухайлбал "Компьютер таймс" сэтгүүлийн бүтэн жилийн 10 дугаартаа фото мэдээ нэг харин фото сурвалжлага огт нийтлээгүй байна. Судалгаанд хамрагдсан сэтгүүлүүдээс "Гялбаа", "UPTOWN" фото сурвалжлага нийтэлсэн бөгөөд "UPTOWN" сэтгүүл дугаар болгондоо 1-7 фото сурвалжлага нийтэлжээ. Харин "Гялбаа" сэтгүүл 8 дугаартаа 1-3 фото сурвалжлага нийтлэсэн байна. Ингэхдээ энэ хоёр сэтгүүл нь фото сурвалжлагаа "Photo news" буландаа оруулсан нь фото мэдээ, фото сурвалжлагаа хольж ойлгож байгааг харуулж байна. Ер нь фото нийтлэлийн ихэнхийг нь сурвалжлага гэж үзэх үндэслэл бол нэг үйл явдлыг өрнөл хөдөлгөөн дунд нь буулгасан таваас дээш зураг нийтлэгдсэн явдал болно. Фото сурвалжлага нь ихэвчлэн далд рекламн шинжийг агуулсан байсан. Тухайлбал "Гялбаа" сэтгүүлийн №59 дугаарт нийтлэгдсэн "Be" брэндийн задгай талбайн шоуны тухай, "Орифлэймийн Шилдэг захирлуудын семинар болж өндөрлөлөө", мөн "UPTOWN" сэтгүүлийн №23 дугаарт нийт 7 фото сурвалжлага нийтлэгдсэнээс "Prosounds studio", "Монголын сайхан ээжүүд" зэрэг нь рекламн шинжтэй болсон байна.

Сэтгүүлийн хувьд гэрэл зураг бол дээр дурдсанчлан мэдээлэл дамжуулахаас гадна уншигчдын анхаарлыг татах, худалдан авалтыг өдөөхөд хамгийн чухал нөлөө үзүүлдэг хөшүүргийн нэг байдаг. Тиймээс сэтгүүлийн гэрэл зурагт уран сайхны болон өнгө, чанарын асуудал нэн чухал байдаг. Гэрэл зургаар ямар нэгэн өгүүлэмж, санааг илэрхийлэхийг фото зохиомж гэнэ. Тодорхой сэдвийн хүрээнд зөвхөн гэрэл зургийн зохиомжоор өгүүлж байгаа сэтгүүлийн

энэ бичлэгийн төрөл зүйл нь цэвэр уран бүтээлийн шинжтэй юм

"Uptown" сэтгүүл нь дугаар бүртээ фото зохиомж оруулдаг бөгөөд энэ нь "Гоо ертөнц", "Нүүрэнд" зэрэг буланд нийтлэгддэг. Фото зохиомж нь мэргэжлийн нарийн мэдрэмж шаардахаас гадна уншигчдад сэтгэлийн, гоо зүйн таашаал өгдөгөөрөө онцлогтой. Жишээ нь "Uptown" сэтгүүлийн №19 дугаарт жүжигчин Б.Амарсайхан зочилж, өөрийн шинэ өнгө төрхийг гаргасан байна. Сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлд эзлэх хэмжээ, агуулгын багтаамжаараа хамгийн том бичлэгт өгүүлэл тооцогддог.

Сонгож авсан баримтад тулгуурлан түүний хөгжил, үйл явц, учир шалтгааныг урт удаан хугацаанд гаргах замаар үнэлэлт өгч, дүгнэлт хийдэг шинжлэлт бичлэгийн төрлийг өгүүлэл гэж нэрлэдэг. Өгүүлэл нь бичлэгийн төрөл зүйлийн дотроос сэдвийн хамрах хүрээгээрээ хамгийн өргөн, мэдээллийн багтаамжаараа илүү, танин мэдэхүй, гэгээрүүлэх чиг хандлагыг өөртөө агуулсан бичлэгийн төрөл зүйл юм. Тийм ч учраас энэхүү чанараараа сонинд бус сэтгүүлд хамгийн их тохирох бичвэр байдаг. Яагаад гэвэл сэтгүүлд цаг хугацааны хувьд үнэ цэнээ алдахгүй, мэдээллийн багтаамж сайтай, далайцтай бичлэгүүд орсноор уншигчдын эрэлт хэрэгцээг хангаж, сониноос сэтгүүлийн ялгарах үндсэн онцлогийг тодотгож өгдөг. Тиймээс сайн өгүүлэл нь сэтгүүлийн амин чухал бичвэр болдог. Сэтгүүлийг уншвартай, сонирхолтой, өгөөжтэй байлгахад нэн чухал үүрэг гүйцэтгэдэг бичвэр яахын аргагүй өгүүлэл билээ. "Сэтгүүл зүй хоёр гол зүйлд түшиглэн үйл ажиллагаагаа

явуулдаг. Нэг талаар өдөр тутмын хамгийн гол чухал, цаг үеийн үйл явдлын талаар шуурхай мэдээлэх, нөгөө талаар тэр үйл явдал, үзэгдэл баримтыг задлан шинжлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх, тайлбарлах болно⁵. Энэ хоёр шинжийг агуулсан бичлэгт өгүүлэл багтдаг. Тиймээс өгүүллийн хувьд тоог бус чанарыг анхаарах хэрэгтэй болдог.

Судалгаанд хамрагдсан сэтгүүлүүдээс дугаар бүртээ өгүүлэл нийтэлсэн нь байсангүй. Энэ нь өгүүллийн үнэ цэнийг илтгэж байгаа бас нэгэн баримт юм. Бүтэн жилийн хугацаанд өгүүлэл огт нийтлээгүй сэтгүүл байхгүй бөгөөд "UPTOWN"-д 40, "Алтангадас"-т 17, "Гялбаа"-д 12, "TV ZONE"-д 16, "Компьютер таймс"-т найман өгүүлэл хэвлэгдсэн байна. Өгүүлэл төрөл бүрийн сэдвийг хөнддөг ба үүгээрээ амьдралын олон талыг харах боломжийг уншигчдад өгдөг.

Орчин үеийн сэтгүүлд хөрөг нэлээд дэлгэрсэн болох нь судалгаанаас харагдаж байна. Ингэхдээ нийгмийн бүхий л салбарын алдартай хүмүүсийн хөргийг уншигчдад толилуулдаг. Хөрөг найруулал нь хүний оюуны ертөнц, зан чанар, сэтгэл санааны дадал зуршил, тодорхой үйлдэл, түүний үр дагаварыг нээн үзүүлдэг. Хөрөглөсөн найруулалд сэтгэл санааны дүрслэл нь уран сайхны гол арга болдог. Ингэхдээ тухайн баатрынхаа оюун санаа, шинж төрх, зан байдал, үйл хөдлөл, үзэл санаа, үг яриа, амьдралын замнал, давтагдашгүй онцлог, ололт амжилт, саад бэрхшээлийг даван туулсан туршлага, хүсэл сонирхлыг тусгадаг.

Тухайлбал "Гялбаа", "UPTOWN" сэтгүүл дугаар бүртээ хөрөг нийтэлдэг. "UPTOWN" сэтгүүлийн 12 дугаарт 32

хөрөг гарсан бол "Гялбаа" сэтгүүлийн 12 дугаарт 34 хөрөг нийтлэгдсэн байна. Дунджаар эдгээр сэтгүүлийн нэг дугаарт гурван хөрөг гардаг байна. Тэгвэл "Алтангадас" сэтгүүлийн найман дугаарт 15 хөрөг нийтлэгдсэн бөгөөд нэг дугаарт дунджаар хоёр хөрөг нийтлэгджээ. Өмнөх хоёр сэтгүүлийн дугаар бүрт хөрөг гарсан бол энэ сэтгүүлийн хувьд зарим дугаарт огт хөрөг гараагүй байна. Харин "Компьютер таймс" сэтгүүлийн хувьд нэг ч хөрөг гараагүй байна. Эдгээр хөргөөс хамгийн сонирхолтой нь "Гялбаа" сэтгүүлийн "Минийхээр", "Style changing" булан юм. "Минийхээр" буланд ямар нэгэн зүйлийн талаарх өөрийн үзэл бодол, дүгнэлтийг өөрөө өөрийнхөөрөө тайлбарлаж, хөргөө өөрөө бүтээдэг бол "Style changing" буланд өмнөхөөсөө огт өөр, өөрийн шинэ өнгө төрх бүхий хөрөг нийтэлдэг.

Харин "UPTOWN" сэтгүүл нүүрийг нь чимсэн хүний хөргийг бүтээхийн зэрэгцээ дэлхийн алдартнуудын хөргийг орчуулан нийтэлдэг. Жишээ нь №16 дугаарт алдарт жүжигчин Мэрилин Монрогийн тухай "Мэрилин Монрогийн үхэл", №23 дугаарт ОХУ-ын ерөнхийлөгч Дмитрий Медведевийн "ОХУ-ын ерөнхийлөгч АНУ-ын ерөнхийлөгчөөс дөрөв дахин бага цалинтай", алдарт жүжигчний тухай "Хед Леджерийн сүүлчийн өдрүүд" хөргийг нийтэлсэн байна. Мөн "Алтангадас" сэтгүүл "Оддын амьдрал", "Дугаарын зочин" буландаа ямар нэгэн алдартны хөргийг нийтэлдэг. Жишээ нь №70 дугаарт Их мастер Б.Мөнгөнтуулын тухай "Шатарчин удмаараа бахархдаг", "Майкл Блумберг 24 насандаа дэлхийн хэмжээний тэрбумтан болж чаджээ" хөрөг нийтлэгдсэн байна.

Сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлд тогтмолжих хандлагатай болж байгаа жанрын нэг нь редакцийн өгүүлэл мөн.

Редакцийн өгүүлэл нь бичлэгийн төрөл зүйлийн өгүүлэлд хамаардаг бөгөөд ихэвчлэн нэмэлт мэдээллийг уншигчдад өгөх чиг зорилгыг өөртөө агуулдаг. Редакцийн зүгээс уншигчдадаа хандан шинэ дугаарынхаа танилцуулга хийгээд сонин содон мэдээ, мэдээлэл төдийгүй тухайн үйл явдлын талаарх өөрсдийн байр суурийг илэрхийлдэг бичвэр юм.

Судалгаанд хамрагдсан сэтгүүлүүдээс "Алтангадас" нь "Редакцийн зурвас", "UPTOWN" нь "Эрхлэгчийн захидал", "Гялбаа" нь "Редакцийн зурвас" буланг тогтмол ажиллуудаг

бол "Компьютер таймс" сэтгүүл 2009 оны эхний дугаар (028)-ынхаа "Редакцийн зурвас" буланд "2009 онд шинээр төрсөн КТ СЭТГҮҮЛ ТАНЫ гарт" өгүүлэл хэвлэсэн байна. Харин "TV ZONE" сэтгүүл хагас жилийн 25 дугаарынхаа есөд нь редакцийн өгүүлэл нийтэлсэн байна. Ингэхдээ онцгой үйл явдал тохиодог саруудад "Редакцийн зурвас" бичдэг. Тухайлбал Ардын хувьсгалын баярыг тохиолдуулан 2009 оны 7-р сарын №60 дугаарт, 9-р сарын эхний долоо хоногийн дугаарт Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулж, 10-р сарын эхний дугаартаа 4 улирлын эхний дугаар хэмээн онцолж редакцийн өгүүлэл гаргасан байна.

Сэтгүүлд тоо болоод сэдвийн хувьд хамгийн түгээмэл бичлэгийн төрөл зүйл нь зөвлөгөө мөн. Зөвлөгөө нь тогтмол хэвлэлийн бичлэгийн уламжлалт зүйлийн нэг юм. Нийгмийн болон хувийн амьдралд тулгарч байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн эх бичвэр, уншигчдад эрэлт хэрэгцээтэй байгаа мэдээллийг зөвлөмж, зөвлөгөө гэж нэрлэдэг. Амьдрал ахуйн, эрүүл мэндийн, гоо сайхны, хүмүүжил боловсролын, эдийн засгийн, харилцааны, амтат зоог бэлтгэх зэрэг зөвлөмж сэтгүүлд хамгийн их дэлгэрчээ. Түүнчлэн эхнэр, нөхөр, амраг хосуудад сексийн амьдралын талаар зөвлөх нь түгээмэл байна.

«

Орчин үеийн сэтгүүлд хорог нэлээд дэлгэрсэн болох нь судалгаанаас харагдаж байна. Ингэхдээ нийгмийн бүхий л салбарын алдартай хүмүүсийн хөргийг уншигчдад толилуулдаг. Хорөглөсөн найруулалд сэтгэл санааны дүрслэл нь уран сайхны гол арга болдог.

»

Судалгаанд хамрагдсан бүх сэтгүүлд дугаар алгасалгүйгээр зөвлөгөө нийтлэгджээ. Нэг дугаарт дунджаар 7-10 зөвлөгөө нийтлэгдэж байна. "Алтангадас"-ын №65, 66 дугаарт 10, "Гялбаа"-гийн №59 дугаарт 13, "Компьютер таймс"-ын №08 (035) дугаарт 27, "UPTOWN"-ы №16 дугаарт 10, "TV ZONE"-ы 12-р сарын 14-20-ны дугаарт 23 зөвлөгөө нийтлэгдсэн нь сэтгүүл тус бүрийн хувьд хамгийн олон зөвлөгөө нийтлэгдсэн дугаар юм. Тухайлбал "UPTOWN" сэтгүүлийн №16 дугаарт "Түүний зовлонг хуваалц", "Ердийн эрчүүдийн этгээд хүслүүд", "Зөв хэмнэх 8 арга", "Сэтгэл мэдрэлийн өвчин", "Гэрийн нөхцөлд үсээ арчлах шилдэг арга буюу шидэт маскууд",

"Ханиад буюу дархлаа", "Сурчихсан байхад ичихгүйгээргүй 14 зүйл", "Өөрт тохирсон интерьерийг хэрхэн зөв сонгох вэ?", "Сэтгэлийн тэгш оршихуй ба ихэмсэг оршихуйн нууц", "Дарсны чанарыг танихуй" гэсэн 10 зөвлөгөө орсон байна. "Компьютер таймс" сэтгүүлийн хувьд мэдээлэл технологийн орчинд ажиллах зөвлөгөө, вирус, гадны халдалтаас хэрхэн хамгаалах, түүнчлэн хэрэглээний болон бусад мэргэжлийн програм дээр ажиллах хичээлүүдийг цувралаар нийтэлдэг.

Нарийн мэргэжлийн сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлийн хувьд голлох байр суурийг тайлбар эзэлж буй нь судалгаанаас тодорхой байна. Тайлбар нь

хэср төрөл байх бөгөөд шинжлэх ухааны бүтээлүүдийн тайлбар бол үнэлэлт, дүгнэлт өгөх зорилго бүхий баримтат мэдээллүүдийг агуулсан байдаг. Харин нийтэд зориулсан бүтээлүүдийн тайлбар нь түүх-утга зохиолын хувьд үнэлэлт өгч, дүгнэлт хийсэн шинжтэй байдаг.

Судалгаанд хамрагдсан сэтгүүлээс "Компьютер таймс"-д хамгийн олон тайлбар хэвлэгдсэн бөгөөд бүтэн жилийн дугаарт нийт 191 орсон байна. Энэ нь нэг жилд хэвлэгдсэн нийт материалын 23.7%-ийг эзэлж байна. Үүнд шинжлэх ухааны бүтээлүүдийн тайлбар байхаас гадна шинэ тоглоом зэргийн тайлбарыг ихээр оруулсан байна.

Хүснэгт №3

Тайлбар

д/д	Сэтгүүлийн нэр	Алтангадас	Гялбаа	Компьютер таймс	TV ZONE	UPTOWN
1.	Тайлбарын тоо	8	4	191	31	38
2.	Нийт материалд эзлэх хувь	424/1.9%	353/1.1%	805/23.7%	1254/2.5%	839/4.5%

Тайлбартай харьцуулахад хэмжээний хувьд арай том, агуулгын хувьд илүү өргөн хүрээг хамарч байгаа бичлэгийн төрөл зүйл нь тайлбар өгүүлэл юм. Тухайн асуудлыг тал бүрээс нь тайлбарлаж дүгнэхээс гадна нэг сэдвийн хүрээнд олон зүйлийг багтаан оруулсан бичлэг юм. Тайлбар өгүүлэл нь тайлбарын нэгэн адил олон нийтэд зориулсан сэтгүүлд төдийлөн олноор байхгүй ч мэргэжлийн сэтгүүлд давамгайлах бичлэгийн төрөл зүйл болох нь судалгаанаас харагдлаа. Тухайлбал, "Гялбаа"

сэтгүүлд 12, "UPTOWN" сэтгүүлд 8, "TV ZONE" сэтгүүлд 28 хэвлэгдэж, тогтмол гардаггүй байна. Харин "Алтангадас", "Компьютер таймс" сэтгүүлийн хувьд дугаар бүрт тогтмол орсон байна. Жишээ нь "Алтангадас" сэтгүүлийн бүтэн жилийн дугаарт нийт 19, "Компьютер таймс" сэтгүүлд 101 тайлбар өгүүлэл хэвлэгджээ.

Сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлд шинээр гарч ирж байгаа өвөрмөц жанр нь танилцуулга юм. Танилцуулга нь аливаа юмс, үзэгдлийн тухай мэдээлэл өгч,

дотоод мөн чанар, хэрэглээ зэргийг тодруулдаг.

Судалгаанд хамрагдсан сэтгүүлүүдэд танилцуулга нь дугаар алгасалгүйгээр тогтмол хэвлэгдсэн байна. Зөвхөн "Гялбаа" сэтгүүл таван дугаартаа л цөөн тооны танилцуулга хэвлэснээс бусад сэтгүүлийн хувьд танилцуулга нь тодор-

хой хувь эзэлсэн голлох бичлэгийн төрөл зүйлийн нэг нь болж байгааг дараах хүснэгт харуулж байна.

Түүнчлэн танилцуулгыг дотор нь шинэ ном, кино, үйлчилгээ, бүтээгдэхүүн, байгууллага, техник технологи, үзвэр гэх мэтчилэн ангилж болохоор байна.

Танилцуулга

Хүснэгт №4

д/д	Сэтгүүлийн нэр	Алтангадас	Гялбаа	Компьютер таймс	TV ZONE	UPTOWN
1.	Танилцуулгын тоо	58	10	254	166	134
2.	Нийт материалд эзлэх хувь	424/13.7%	353/2.8%	805/31.5%	1254/13.2%	839/17%

Сонин, сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлийн дотроос уншигчдын анхаарлыг байнга татаж байдаг бичлэг нь зурхай юм. Тиймээс ч өнөөдөр бараг бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл зурхай нийтэлдэг болжээ. Ялангуяа нэг зурхайчийн зурхайг тогтмол хэвлэснээр өөрийн гэсэн худалдан авагчдын хүрээтэй болж байна. Тухайлбал ихэнх хэрэглэгчид Л.Тэрбишийн зурхайн зурлагад итгэдэг байх жишээтэй. Аливаа сэтгүүлд өрнийн болон дорны гэсэн хоёр чиглэлийн зурхайг долоо хоног, сараар хэвлэж байна. Зурхай нь тухайн сэтгүүлийн тогтмол булан болсон сэтгүүл гэвэл "Гялбаа", "TV ZONE" байна.

Зурхайн нэгэн адилаар уншигчдын унших дуртай бичлэг нь төрөл бүрийн сонжоо байдаг. Хүний зан чанар, зориг тэвчээр, оюуны чадавхи, хүсэл таашаал зэрэг дотоод сэтгэлийн нууцыг мэдэхэд чиглэгдсэн шалгууртай асуултын багцыг сонжоо гэнэ. Сонжоо нь ихэвчлэн дээрх

чанаруудын аль нэгээр дагнасан шинжтэй байх бөгөөд уншигч өөрийнхөө сэтгэх чадвар, тодорхой зан чанарыг мэдэж авахад туслах зорилготой байдаг. Мөн сонжоо нь хүний өөрийгөө олох, өөрийгөө таньж, нээхэд тусалдаг бичлэгийн туслах зүйл билээ. Асуулт бүрт хариулж, болзолт оноонуудыг нэмж бодсоны эцэст зан чанарын тодорхой үр дүнг олж харах замаар өөрийгөө сонжих хэлбэр хамгийн их дэлгэрсэн байна.

Судалгаанаас харахад хүүхэд, залуучуудын, эмэгтэйчүүдийн, гоо сайхны чиглэлийн сэтгүүлд сонжоог илүү их нийтлэгдсэн байна. Тухайлбал, "Гялбаа" сэтгүүл нийт 13, "TV ZONE" сэтгүүл 26, "UPTOWN" сэтгүүл таван сонжоо нийтэлсэн байна. Харин "Алтангадас", "Компьютер таймс" сэтгүүлийн хувьд нэг ч сонжоо нийтлэгдээгүй нь эдгээр сэтгүүлийн чиглэлтэй холбоотой юм. Сонирхлын болон олон нийтэд чиглэсэн сэтгүүлд сонжоо тогтмолжих хандлага

байгаа нь бидний хийсэн судалгаанаас тодорхой байна. Үүнд "Гялбаа" сэтгүүлийн бүтэн жилийн дугаарт нийт 13, "TV ZONE" сэтгүүлд 26, "UPTOWN" сэтгүүлд тав, "Алтангадас" сэтгүүлд нэг хэвлэгдсэн байна.

Богино өгүүлэг, үнэ ханш, мэндчилгээ, дууны үг, хуваарь, зүйр үг, онигоо, шүлэг, санал асуулга, үлгэр, оньсого, үгийн сүлжээ зэрэг нь нэг дугаарт харилцан адилгүй тоотой орж байгаа ч эдгээрийн ач холбогдол бусад бичлэгийн төрөл зүйлтэй харьцуулахад төдийлөн өндөр биш юм. Тиймээс эдгээрийг жижиг бичлэгүүд хэмээн ангилан авч үздэг. Нийтлэлийн бодлого, үр өгөөжид төдийлөн нөлөөлдөггүй бичвэрүүд учраас дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагагүй гэж үзлээ. Гэхдээ эдгээр нь сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлийн бүтцэд багтан тогтмолжих хандлагатай байгааг дурдахгүй өнгөрч болохгүй юм. Ялангуяа үгийн сүлжээ, богино өгүүлэл, онигоо, зүйр үг зэрэг нь хэд хэдэн дугаар дамнах, эсвэл дугаар бүрт гарч байна. Жишээ нь "TV ZONE" сэтгүүлийн хагас жилийн 25 дугаарт үгийн сүлжээ, өгүүлэл нь тогтмол нийтлэгдэж байна.

Сэтгүүлийн бичлэгийн нэг онцлог нь одоо цаг болон ирээдүй цагт хандаж байгаа бичвэрүүд төдийлөн гардаггүй. Учир нь сэтгүүл нь сониныг бодвол цаг хугацааны хувьд шуурхай бус байдаг. Мөн хүртээмжийн хувьд өдөр тутмын сонин, телевизийг бодвол харьцангуй бага, идэвхтэй байдлын хувьд тийм ч өндөр биш, харин мэдээллийн багтаамж сайтай байдаг. Учир нь сониныг бодвол сэтгүүл хэд дахин олон хуудастай байхаас гадна зугаацуулах хандлага илүүтэй байдаг. Сонины бичлэгийн нэг

хэсэг зөвхөн мэдээлэх үүрэгтэй байхад нөгөө хэсэг нь хэрэг явдлын шалтгаан нөхцлийг тодруулж, үр дүнг илэрхийлдэг бол гурав дахь хэсэг нь уран дүрслэл ба нийтлэлийн аргыг хослуулах замаар үзэгдэл, юмсын шинж чанарыг нээж, үзүүлдэг байна. Харин сэтгүүлд мэдээлэх, юмс үзэгдлийн шинж чанарыг нээж илрүүлэхдээ гол бус хамгийн чухал нь тухайн сэтгүүл хэнд хандаж гарч байгаа, тэр хүрээнд материалуудаа бэлтгэдэг.

Сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйлийг тогтоохын тулд "Алтангадас", "Гялбаа", "Компьютер таймс", "UPTOWN", "TV ZONE" сэтгүүлүүдийг харьцуулан судалж дараах дүгнэлтэнд хүрлээ. Сонгож авсан сэтгүүлүүд нь өнөөгийн зах зээл дээр борлогдож байгаа сэтгүүлүүдийг төлөөлөх, тэдгээрийн өнгө төрх, байр суурийг илэрхийлж чадахуйц нэр хүнд бүхий, өөрийн гэсэн уншигч, захиалагчидтай хэвлэл юм.

“Компьютер таймс” нь зөвхөн компьютер сонирхогчдод зориулагдсан сэтгүүл бөгөөд компьютертэй холбоотой бүхий л мэдээллийг нийтэлдэг учраас мэдээ, тайлбар, ярилцлага, зөвлөгөө, нийтлэл гэсэн бичлэгийн төрөл зүйлүүд голлож байна. “UPTOWN” сэтгүүл нь орчин үеийн хүмүүсийн амьдралын хэв маяг, урлаг, спорт, эрүүл мэнд, хувцас загвар, гоо сайхан, хүмүүс болон нийгмийн харилцаа, улс орнуудын сонин хачин, танин мэдэхүйн мэдээ мэдээллүүд нийтлэгддэг. 2007 онд “Uptown” нь Хэвлэлийн Хүрээлэнгийн судалгаагаар Монголын хамгийн олон уншигчтай сэтгүүлээр шалгарсан юм.

“UPTOWN” сэтгүүл нь “Хотын соёл”, “Урлаг”, “Тэрбумтнууд”, “Зочин”, “Сэтгэл

зүй", "Харилцаа", "Нүүрэнд", "Uptown girl", "Мода Тренд", "Дэлхийн хүн", "Оддын мэдээ", "Зөвлөгөө", "Эрүүл мэнд", "Шинэ технологи", "Сонирхуулахад", "Сарын онцлох хүн", "Том хотууд", "Амьтан" зэрэг томоохон тогтмол булантай. Бичлэгийн хувьд мэдээ, танилцуулга, зүйр үг, ярилцлага, зөвлөгөө, фото сурвалжлага, тайлбар, хөрөг зэрэг сэтгүүл зүйн хэд хэдэн бичлэгийн төрөл зүйлээр дагнадаг байна.

Мэдээний дараах хэрэглэгддэг бичлэгийн төрөл зүйл бол хөрөг юм. Хөрөг нь голдуу гадаадын алдартнуудын тухай орчуулгын материал байдаг. "UPTOWN" сэтгүүлийн "Дэлхийн хүн", "Хөрөг", "Тэрбумтнууд" зэрэг буланд хөрөг нийтлэгддэг. "Зочин", "Сарын онцлох хүн" буланд ярилцлага гардаг. Тайлбар, танилцуулга, зөвлөгөө бол орчин үеийн сэтгүүлүүдийн гол бичлэгийн төрөл зүйл болоод байгаа нь бидний судалгаанаас харагдаж байна.

Сэтгүүл нь хэзээ ч гаргаж ирээд уншсан хүнд хүртээмжтэй, цаг хугацааны байдлыг харгалзахгүйгээр мэдээллүүд, нийтлэлүүд нь хүнд хүрч байдаг онцлогтой юм. Харин орчуулгын материал түлхүү гаргадаг нь учир дутагдалтай санагдлаа.

"Гялбаа" нь 90 нүүрээр сар тутам гардаг бөгөөд охид бүсгүйчүүд, эмэгтэйчүүдэд зориулагдсан сэтгүүл юм. "Гялбаа" сэтгүүл "Чиг хандлага", "Make up", "Lady's tet-a-tet", "Сонжоо", "Shopping", "Урлаг", "Style changing", "Эрчүүдийн яриа", "Минийхээр", "Карьер" гэсэн тогтмол булантай. "Гялбаа" сэтгүүлийн онцлог, давуу тал нь фото зургийг чанарын өндөр төвшинд, зохиомжтой, хүний сэтгэлийг татахуйц авч нийтэлдэг

явдал юм. Энэ нь "Гялбаа" сэтгүүлийг фото агентлаг гаргадагтай холбоотой. Энэ сэтгүүлийг "UPTOWN"-тай харьцуулахад орчуулгын бус, сэтгүүлчийн бүтээл түлхүү гаргадаг. Энэ нь тус сэтгүүлийн бусдаас ялгарах хамгийн том давуу тал юм. "Гялбаа" сэтгүүлийн голлох бичлэгийн төрөл зүйл нь зөвлөгөө, ярилцлага, мэдээ, хөрөг, фото мэдээ, сурвалжлага байна. Харин тогтмолжиж, өөрийн гэсэн өнгө төрхийг олсон жижиг бичлэгийн төрөл зүйл нь зурхай юм. Зурхайг нэг дугаарт хоёр янзаар нийтэлж байна. Ингэхдээ тухайн сарын бүх ордны зурхайг өвөрмөц шийдэлтэй зурагтай нийтэлдэг бөгөөд сар бүрийн зурхайн зураг өөр өөр байдаг. Түүнчлэн тухайн сард төрсөн хүний зурхайг онцгойлон авч тусгайлан дэлгэрүүлэн нийтэлдэг нь уншигчдын анхаарлыг татахаар байна.

"Алтангадас" сэтгүүл нь 2003 оноос хойш 7 жил тасралтгүй хэвлэгдэж, өдгөө 76 дугаарыг уншигчдадаа хүргэсэн, сэтгүүлийн зах зээл дээр өөрийн гэсэн өнгө төрх, байр суурийг эзлээд байгаа хэвлэл юм. "Алтангадас" сэтгүүл нь 48 нүүрээр хэвлэгдэн гардаг бөгөөд "Мэдээ", "Хөгжлийн төлөө хамтдаа", "Дугаарын зочин", "Менежмент", "Өөрийгөө тольдохуй", "Эрүүл мэнд", "Боловсрол", "Шинжлэх ухаан, технологи", "Ертөнц", "Эдийн засаг", "Хүүхэд ба гэр бүл" гэсэн тогтмол булантай. "Алтангадас" сэтгүүлийн хувьд зөвлөгөө, танилцуулга, мэдээ, ярилцлага, захидал, өгүүлэл голлох бичлэгийн төрөл зүйл нь болж байна.

"TV ZONE" нь "Гэр бүлийн гишүүн бүрт" гэсэн уриатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг олон нийтэд зориулсан сэтгүүл бөгөөд 2008 оны 3-р сарын 1-

нээс эхлэн хэвлэгдэж нийт 123 дугаарыг уншигчдын гар дээр тавиад байна. "Movie", "Z-News", "Танин мэдэхүй", "Зөвлөгөө", "Сурвалжлага", "Ярилцлага", "Z-Love", "Z-edu", "Sport", "KIDS", "Эрүүл мэнд", "Зурхай", "Fashion", "Сонин хачин" гэсэн тогтмол булантай. Мэдээ, зөвлөгөө, танилцуулга, ярилцлага, тайлбар, тайлбар өгүүлэл, зурхай, сонжоо, богино өгүүлэл, үгийн сүлжээ зэрэг нь тус сэтгүүлийн голлох бичлэгийн төрөл зүйл болсон байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд судалгаанд хамрагдсан сэтгүүлүүдэд орчуулгын материал олноор нийтлэгдэж байгаад шүүмжлэлтэй хандмаар санагдаж байна. Сэтгүүлд сэтгүүлч бус орчуулагч гол үүрэг гүйцэтгэж байна гэж дүгнэж болно. Гадаадын томоохон сэтгүүлд сэтгүүлчдийн ур чадварыг сорьсон, нийгэмд дуулиан шуугиан тарихуйц материал өгөхийг редакци шаардаж, хатуу бодлого баримтлан ажиллаж, түүгээрээ зах зээл дээр өрсөлддөг бол манайд тийм биш байгаа нь ажиглагдлаа. "TV ZONE" сэтгүүлийн "Асуултын цаана асуудал" буланд нийтлэгдсэн сэтгүүлч Х.Жавзмаагийн бичлэгүүд асуудал дэвшүүлсэн, гарц эрэлхийлсэн, сонирхол татахуйц байлаа. Харин бусад сэтгүүлийн хувьд иймэрхүү бичлэг дутмаг байгаа нь судалгаанаас харагдлаа. Сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйл баяжиж, бичлэгийн төрөл зүйлүүд өөр хоорондоо уусах маягтай болж ирсэн нь ажиглагдлаа. Тухайлбал тайлбар нь хэмжээний баримтыг өгүүлэх байдлаараа өгүүлэлтэй нэлээд адилхан болсон бөгөөд ийм бичлэгийг тайлбар өгүүлэл гэж ангилан авч үзэхээс өөр аргагүй байна.

Сэтгүүлийн бичлэгийн төрөл зүйл нь сэтгүүл зүйн бичлэгийн мэдээллийн, шинжлэлт, нийтлэл-уран сайхны, бичлэгийн жижиг буюу туслах зүйлүүд гэсэн төрөлд ангилагдаж байна. Түүн дотроос мэдээ, ярилцлага, хөрөг, тайлбар, танилцуулга, зөвлөгөө, өгүүлэл, зурхай, сонжоо зэрэг нь сэтгүүлийн бичлэгийн голлох зүйл болжээ. Сонины хувьд "Зууны мэдээ" сонины 2000-2005 оны нийт 144 дугаарт хийсэн бичлэгийн төрөл зүйлийн судалгаанаас харахад мэдээ 62.4%, сурвалжлага 4.4%, ярилцлага 10.6%, тайлан 0.5%, шуурхай тайлбар 0.7%, тойм 3.1%-ийг эзлэх бөгөөд эдгээрийн нийлбэр нь 81.7% болж байна. Ийнхүү тус сонинд мэдээллийн бичлэгийн төрөл зүйл 81.7%-тайгаар давамгайлж байна. "Өнөөдөр" сонины 2004 оны 3-р сарын бүх дугаарт нийт 898 материал орсноос мэдээ 688, ярилцлага 72, өгүүлэл 50, тойм 22, сурвалжилсан тэмдэглэл 17 орсон байна. "Улаанбаатар таймс" сонины 2005 оны 3-р сарын хорин дугаарт нийт 676 мэдээ хэвлэгдсэн бөгөөд 9 орчим хувь буюу 63 нь гадаад мэдээ байв. Өөрөөр хэлбэл өдөрт дунджаар 35 дотоод мэдээ, 3 гадаад мэдээ гардаг гэсэн үг. Тухайн сард ярилцлага 107, асуудал дэвшүүлсэн өгүүлэл 28, сурвалжлага 18, тойм 12 хэвлэгдсэн байна. "Улаанбаатар таймс" сонинд нэг сарын хугацаанд нийт 860 материал гарсны 676 буюу 78.6% нь мэдээ, 12 буюу 1.4% нь тойм, 18 буюу 2% нь сурвалжлага, 28 буюу 3.25% нь асуудал дэвшүүлсэн өгүүлэл, 7 буюу 0.8% нь хөрөг, бусад бичлэгийн төрөл зүйлүүд 10 буюу 1.1%-ийг тус тус эзэлж байна. Сонины бичлэгийн төрөл зүйлтэй

харьцуулахад сонин, сэтгүүлийн бичлэ-
гийн төрөл зүйлүүд бие биенээсээ
ялгарах онцлог шинжтэй нь тодорхой
харагдаж байна.

Ишлэл

- ¹ Норовсүрэн Л. 2005. Сэтгүүл зүйн
бичлэгийн төрөл, зүйл. УБ., 272 дахь тал.
- ² Норовсүрэн Л. 2003. Монголын
сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар боть. УБ.,
224 дэх тал.
- ³ Зулькафиль М. 2005. Сэтгүүл
зүйн тайлбар толь. УБ., 273 дахь тал.
- ⁴ Норовсүрэн Л. 2003. Монголын
сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар боть. УБ.,
229 дэх тал.
- ⁵ Зулькафиль М. 2007. Орчин
үеийн сэтгүүл зүй. УБ., 173 дахь тал.

Ном зүй

1. Дэлэг Г. 1965. Монголын тогтмол
хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.,
2. Зулькафиль М. 1994. Өөрчлөлт
шинэчлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл. УБ.

3. Зулькафиль М. 2005. Сэтгүүл
зүйн тайлбар толь. УБ.
4. Зулькафиль М. 2007. Орчин
үеийн сэтгүүл зүй. УБ.
5. Норовсүрэн Л. 1996. Монголын
тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
6. Норовсүрэн Л. 2000. Монголын
сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.
7. Норовсүрэн Л. 2005. Монголын
нийтлэл. Дэд дэвтэр УБ.
8. Норовсүрэн Л. 2005. Сэтгүүл
зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
9. Маккей Дж. 2002. Все о журна-
лах. М.

Summary

It is from research results clear that genre of journalism is divide onto the information, commentary, publication and essay, review and small item story and etc. From all these, news, interview-portrait, reportage, editorial article, commentary, introduction, recommendation, horoscope, and test are become as leading directions.

I was noticed here that few past years journalism genre is increased and like that, they are combining between themselves.